



МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛОН
ЗАХИРАГЧИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ
ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ГАРГАСАН ЗӨВЛӨМЖИЙН ТУХАЙ

Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн хоёрдугаар зүйлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Нийслэлийн мал эмнэлгийн 2013-2014 оны төсвийн санхүүжилт, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнд Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын тайлантай танилцаж, аудитын хороогоор хэлэлцүүлсэн зөвлөмжийг хавсралтад тусгасанаар хэрэгжүүлсүгэй.

2. Зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөө боловруулан, 2016 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн мал эмнэлгийн газрын арга /А.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хяналтад авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /У.Сауле/-д үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛОН ЗАХИРАГЧ



Р.БУРМАА

НИЙСЛЭЛИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ГАРГАСАН ЗӨВЛӨМЖИЙН ТУХАЙ

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн удирдамжийн дагуу Нийслэлийн мал эмнэлгийн газрын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, түүний хэрэгжилтийн үр дүнд гүйцэтгэлийн болон санхүүгийн дотоод аудит хийсэн дүгнэлт, зөвлөмж:

НЭГ. НИЙСЛЭЛИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАРТ:

1. Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, баталгаажуулалтанд анхаарч, хувийн МЭҮН-дэд тараасан вакцины зарлагын баримт, шаардах хуудсанд хүлээн авсан, хүлээлгэн өгсөн албан тушаалтны гарын үсгийг бүрэн зуруулж хэвших;
2. Шатахуун зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, замын хуудас бүрэн бөглөөгүй, явсан албан тушаалтны гарын үсэг, заалтын тэмдэглэгээ дутуу бичсэн, жолоочийн тооцоо бодсон акт дутуу баримтаар нийт 30963.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчлийг арилгаж, тайланг хянаж баталгаажуулах;
3. Санхүүгийн баримт бүрдүүлэлтийн иж бүрэн, үнэн зөв, нотлогдохуйц байдалд тавих дотоодын хяналтыг сайжруулж, баримтгүй, баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг санхүүгийн бүртгэл тайланд тусгахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
4. Бэлэн мөнгөний орлогыг 24 цагийн дотор Төрийн сангийн харилцах дансанд тушааж, кассын үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлэх;
5. Бараа материал, эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг бүрэн мөрдөж ажиллах;
6. Материалын үлдэгдэл, нөөцийн оновчтой, зохистой тоо хэмжээг хангаж ажиллах;
7. Бараа материалын, эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, үр дүнг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах;
8. Үндсэн хөрөнгийн ангиллын дагуу үнэн зөв бүртгэж 20910.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэн зөв ангиллын дагуу шилжүүлэн бүртгэх;
9. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 73619.6 мянган төгрөгөөр дутуу, 7274.1 мянган төгрөгөөр илүү, нийт 66345.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцоолсон зөрчлийг арилгах;
10. Гэрэл, цахилгааны зардлыг бүртгэл тайланд гарсан зардлын гүйцэтгэлээр тайлах, цаашид хэрэглээний зардлын гүйцэтгэлийг төсвийн гүйцэтгэлийн тайланд бодитойгоор тусгах;
11. Батлагдсан орон тооны хязгаар, албан тушаалын жагсаалтыг мөрдөж ажиллах;
12. Өмнөх хяналт шалгалтын актаар тогтоосон 13000.1 мянган төгрөгийг байгууллагын тайлан бүртгэлд холбогдох албан тушаалтнаас авлагаар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт өглөгөөр бүртгээгүй байна. Цаашид санхүүгийн тайлан бүртгэлд тусгах өр, авлагыг бүрэн тусгаж, холбогдох байгууллага, иргэнтэй тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах;

13. Орон нутаг, дүүргийн хувийн мал эмнэлгүүдэд вакцин, тарилга, биобэлдмэл, шинжилгээний дээж материал хадгалах, тээвэрлэх технологийн шаардлага хангасан явуулын болон суурин хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж, хөргүүрийн систем нэвтрүүлэх;
14. НИТХ-ын 2014 оны 5 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, орон нутгийн төсөвт МЭҮН-үүдэд олгох тарилгын үйлчилгээний хөлсийг бүрэн тусгах асуудлаар нийслэлийн ИТХ-д санал оруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;
15. НМЭГ, ХХААГ-ууд нь ажлын уялдаа холбоогоо сайжруулж, хамтран ажиллах;
16. Нийслэл, дүүргийн Засаг дарга, Өмч газрын харилцааны албадад МЭҮН-үүдийг стандартын шаардлага хангасан ажлын байртай болоход шаардлагатай газрын асуудлыг шийдвэрлэж өгөх талаар санал хүргүүлэх;
17. НМЭГ-аас хувийн МЭҮН-үүдэд олгосон вакциныг бараа материалын тайланд, үйлчилгээний хөлсийг орлого үр дүнгийн тайланд бүрэн тусгаж хоорондын тооцоо нийлсэн актаар хяналт тавьж баталгаажуулж ажиллах;

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАРТ

1. Малын ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлт, малчдыг тамгажуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, шуурхай зохион байгуулах;
2. Хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлж байх;
3. Нийслэлийн мал эмнэлгийн газартай ажлын уялдаа холбоогоо сайжруулж, хамтран ажиллах.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР